

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/03/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мандалговь хот</p> <p>2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70594212 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Сарангуа Утас: 70593113 Цахим хаяг: Saranguab@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Пүрэвбаатар Утас: 70593113 Цахим хаяг: Purevbaatare@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


АГУУЛГА

1.	ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
3.	Аудитын илрүүлэлт.....	8
3.1	Төлбөрийн акт	8
3.2	Албан шаардлага.....	9
3.3	Зөвлөмж	9
4.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <p>ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сүм Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn</p>	<p>ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.УУГАНБАЯР ТАНАА</p>
_____ № _____	_____
_____ -ны № _____ -т	_____
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлангийн аудит хийлээ.</p> <p>“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Асуудлыг онцолсон хэсэг</p> <p>Компани нь тайлант хугацаанд 243,212.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 164,645.7 сая төгрөгийн зардал гарган, 77,057.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна</p> <p>Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.</p> <p>Аудитын гол асуудал</p> <p>Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Тайлант хугацаанд бондын санхүүжилтийн өглөг, хойшлогдсон бондын хөрөнгө дансдуудад өөрчлөлт ороогүй байна.</p> <p>Бусад асуудлын хэсэг</p> <p>Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.</p> <p>Компани худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 106,407.1 сая төгрөгийг баталсан бөгөөд оны дундуур 2 удаа тодотгож 7,796.9 сая төгрөгөөр өсгөн 114,204.0 сая төгрөг</p>	
4826050276	

болгож баталсан байна. Тайланг хугацаанд 91,782.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2025/01/31	2025/12/31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	7,747,307,751.71	15,841,712,640.46
1.1.2	Дансны авлага	25,048,135,679.85	25,103,836,684.84
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,238,084,968.18	2,629,335,521.64
1.1.4	Бусад авлага	274,772,812.91	396,254,540.39
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	48,157,665,018.09	50,276,017,522.84
1.1.6	Бараа материал	45,037,339,027.46	44,192,664,287.01
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,077,793,208.15	673,656,462.47
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах бүлэг хөрөнгө	0.00	0.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	129,581,098,466.35	139,113,477,659.65
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	64,689,488,296.38	50,671,544,288.02
1.2.2	Биет бус хөрөнгө	3,097,527,424.92	2,424,520,868.69
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	26,812,831,123.80	38,995,500,986.59
1.1.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.1.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Хойшлогдсон бондын хөрөнгө	906,061,535,295.81	906,061,535,295.81
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,000,661,382,140.91	998,153,101,439.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,130,242,480,607.26	1,137,266,579,098.76
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,921,160,953.64	9,371,955,355.07
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	42,443,575,705.31	5,215,715,423.70
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	22,648,198,656.60	9,055,731,392.71
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	693,839,129.30	1,182,430,506.52
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд хамаарах өр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	72,706,774,444.85	24,825,832,678.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Урт хугацаат нөөц (өр төлбөр)	2,414,595,900.00	2,414,595,900.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бондын санхүүжилтийн өглөг	849,973,000,000.00	849,973,000,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	852,387,595,900.00	852,387,595,900.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	925,094,370,344.85	877,213,428,578.00
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	Өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	101,000,000.00	101,000,000.00
2.3.2	б) хувийн	0.00	0.00
2.3.3	в) хувьцаат	0.00	0.00

2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	28,703,725,699.86	28,703,725,699.86
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	176,343,384,562.55	231,248,424,820.90
2.3.11	Эздийн өмчийн дүн	205,148,110,262.41	260,053,150,520.76
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,130,242,480,607.26	1,137,266,579,098.76

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
А	Б	1	2
1	Борлуулалтын орлого (цэвэр)	423,463,911,351.68	237,983,841,078.82
2	Борлуулалтын өртөг	172,801,575,644.50	142,383,807,321.30
3	Нийт ашиг (алдагдал)	250,662,335,707.18	95,600,033,757.52
4	Түрээсийн орлого	510,201,175.29	871,982,984.27
5	Хүүний орлого	14,640,667,557.49	4,319,962,146.02
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	150,538,806.40	37,131,964.28
9	Борлуулалт, маркетингийн зардал	32,464,425,856.44	8,681,042,066.46
10	Ерөнхий ба удирдлагын зардал	14,189,015,670.18	6,432,745,774.83
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	1,777,136,750.88	10,078,416,228.49
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	321,101,301.05	1,420,963,137.92
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	217,854,266,269.91	77,057,869,920.23
19	Орлогын татварын зардал	54,534,153,703.30	22,279,798,660.38
20	Татварын дараах ашиг (алдагдал)	163,320,112,566.61	54,778,071,259.85
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	163,320,112,566.61	54,778,071,259.85
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	163,320,112,566.61	54,778,071,259.85
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	100,000,000.00	28,703,725,699.86	13,085,166,037.48	41,888,891,737.34
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00		(61,894,041.54)	(61,894,041.54)
3	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	28,703,725,699.86	13,023,271,995.94	41,826,997,695.80
4	Тайлангийн үеийн цэвэр ашиг	0.00		163,320,112,566.61	163,320,112,566.61
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00			0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000.00			1,000,000.00
7	Зарласан ногдол ашиг	0.00			0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00			0.00
9	2025 оны 01-р сарын 31-ний үлдэгдэл	101,000,000.00	28,703,725,699.86	176,343,384,562.55	205,148,110,262.41
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			126,968,998.50	126,968,998.50
11	Залруулсан үлдэгдэл	101,000,000.00	28,703,725,699.86	176,470,353,561.05	205,275,079,260.91
12	Тайлангийн үеийн цэвэр ашиг			54,778,071,259.85	54,778,071,259.85
13	Бусад дэлгэрэнгүй орлого				0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт				0.00
15	Зарласан ногдол ашиг				0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				0.00
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	101,000,000.00	28,703,725,699.86	231,248,424,820.90	260,053,150,520.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ДҮН	ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮН
А	Б	1	2
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	325,981,499,878.90	207,776,896,809.61
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	325,839,520,775.60	207,478,229,110.81
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	29,631,141.00	29,660,545.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	0.00
1.1.5	Тагаас, санхүүжилтийн орлого	-	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	112,347,962.30	269,007,153.80
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	269,558,835,032.87	188,064,628,478.75
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	7,646,165,832.96	8,329,797,489.10
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	1,999,268,436.15	2,312,751,430.54
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	88,556,008,805.56	61,945,119,348.72
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	9,334,519,579.72	10,069,135,086.25
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	15,038,921,711.30	15,040,644,969.58
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	136,270,272,422.12	78,408,456,6 69.95
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	290,604,926.00	150,763,507.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	10,423,073,319.06	11,807,959,977.61
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	56,422,664,846.03	19,712,268,330.86
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	163,606,994,441.06	6,405,620,548.65
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	151,052,000,000.00	
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусад олгосон зээл, урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	12,554,994,441.06	6,405,620,548.65
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	142,195,275,358.03	16,287,574,394.69
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,094,493,862.38	3,971,650,4 14.71
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,941,116,477.56	12,315,923,979.98
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	130,159,665,018.09	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	0.00
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	21,411,719,083.03	(9,881,953,846.04)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	175,582,951.36	43,469,453,600.72
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад орлого	175,582,951.36	43,469,453,600.72

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	80,034,742,175.15	45,205,363,196.79
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	80,000,000,000.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад зарлага	34,742,175.15	45,205,363,196.79
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(79,859,159,223.79)	(1,735,909,596.07)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,024,775,294.73)	8,094,404,888.75
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,772,083,046.44	7,747,307,751.71
6	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,747,307,751.71	15,841,712,640.46

3. Аудитын илрүүлэлт

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 83,886.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өмнөх жилүүдэд тооцсон 83,886.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг залруулаагүй. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.7-д (*Эргэлтийн хөрөнгө, газар, бараа, материалын нөөц, уран зураг, гар урлал, эртний эдлэл, үнэт эдлэл, эдгээртэй адилтгах бусад эд хөрөнгөд элэгдэл, хорогдол тооцохгүй*) заасныг зөрчсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчил:

Аудитаар нийт 63,954,660.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 9,213.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 42,396,424.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлэн, 21,549,022.6 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- Ёс зүйн хорооны нарийн бичгийн даргад сар бүр 396.0 төгрөгийн урамшуулалт цалин бодож, үндсэн ажлын цалин хөлстэй давхардуулан нийт 1,188.0 мянган төгрөг олгосон. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т (*Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална*), 4.1.6-д (*сахилга баттай байх*), 10.2-т (*Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно*) заасныг;
- Тайлант оны гуравдугаар улирлын байдлаарх цалингийн тооцооллыг шалгахад ээлжийн амралттай хугацаанд 16 хаагчид 8,025.0 мянган төгрөгийн зэргийн нэмэгдэл тооцож, илүү олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т (*Анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*), 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-д (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), 13.7-д (*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*), 20.1.4-т (*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажсаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

- Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан өөрийн албан хаагчдад 50,039.8 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т (*Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална*), 4.1.6-д (*сахилга баттай байх*), 10.2-т (*Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно*) заасныг;
- Тайлант оны гуравдугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд тусгагдсан харилцагч байгууллагуудын 42,326,584.5 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*) заасныг;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 19,800.0 мянган төгрөгийн оффисын албан хаагчдад хувцас худалдаж авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*), 8.2-т (*Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй*) заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн 16,722,008.7 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэх саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2-т (*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*), Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам-ын 5.14-т (*үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах, үнийг шинэчлэн тогтоох зорилгоор санал бэлтгэх, тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хөрөнгийн үнэлгээ хийлгэх*) заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэн арга хэмжээ авч, жилийн эцсийн санхүүгийн тайланд хэрэгжилтийг ирүүлэх.

Зөвлөмжийн хэрэгжилт:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар давтан шалгахад “Тэгш сонголт эстимэйт үнэлгээ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ болон гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т (*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*), 6.4.5-т (*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*), 6.4.8-т (*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр*) заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 4,827,013.9 мянган төгрөгийн батлагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1-т (*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална*), 13.1.1-т (*батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах*), 13.1.2-т (*энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох*) заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өмнөх жилүүдэд тооцсон хуримтлагдсан элэгдлийг залруулаагүй.	1	83,886.5			1	83,886.5	1	83,886.5				
Дүн	1	83,886.5	-	-	1	83,886.5	1	83,886.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хуулийн байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан өөрийн албан хаагчдад урамшуулалт цалин олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	50,039.9			1	50,039.9						
Ёс зүйн хорооны нарийн бичгийн даргад сар бүр урамшуулалт цалин бодож, үндсэн ажлын цалин хөлстэй давхардуулан олгосон.	1	1,188.0	1	1,188.0								

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тайлант оны гуравдугаар улирлын байдлаарх цалингийн тооцооллыг шалгахад ээлжийн амралттай хугацаанд 16 хаагчид зэргийн нэмэгдэл тооцож, илүү олгосон.	1	8,025.0	1	8,025.0								
Санхүүгийн тайлан дахь харилцагч байгууллагуудын авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	42,326,584.5			1	42,326,584.5						
Дүн	4	42,385,837.4	2	9,213.0	2	42,376,624.4	-	-	-	-	-	-

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлийн зардлаар анхны өртөгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй.	1	16,722,008.7					1	16,722,008.7		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин оффисын албан хаагчдад хувцас худалдаж авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	19,800.0			1	19,800.0				
Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх батлагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан.	1	4,827,013.9					1	4,827,013.9		
Байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ болон гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулаагүй.	1						1			
Дүн	4	21,568,822.6	-	-	1	19,800.0	3	21,549,022.6	-	-